



Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл

Сэтгүүл: 2018 оны 1 сар

ТӨСЛИЙН ТУХАЙ

"Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь" (MERIT) төсөл нь олборлох салбарыг үр дүнтэй удирдах төрийн байгууллагуудын арга барилыг чадавжуулснаар Монгол дахь тогтвортой эдийн засгийн өсөлтийг сэргээхэд 6 жил (2016-2023) хувь нэмрээ оруулна. 2017 оны 7 сараас 12 сарын хугацааг хамарсан төсөлтэй холбоотой онцлох мэдээ, мэдээлэл бүхий гурав дахь удаагийн нийтлэлийг толилуулж байна.

Уул уурхай, газрын тосны салбарын статистик

Уул уурхай, газрын тосны чиглэлээр мэргэшсэн төслийн техникийн зөвлөхүүд уул уурхай, газрын тосны салбарын өгөгдөл, мэдээ үүсгэх, ашиглах, тус салбарын зүгээс эдийн засаг, нийгэм болон байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаарх статистик мэдээллийг гаргаж тараах талаар АМГТГ-т зөвлөх үйлчилгээ үзүүлэв. АМГТГ-ын Геологи, хайгуулын хэлтэст цуглуулсан мэдээллийн чанар, нарийвчлалыг сайжруулах, үзүүлэлтүүдийг тогтоох, өгөгдөл цуглуулах, шинжлэх, тайлагнаж мэдээлэх ажилд шаардлагатай өөрчлөлтийг хэрхэн хийх талаар зөвлөгөө өгөв.

АМГТГ-ын статистик мэдээллийн системийг үнэлж, ашиглахтай холбоотойгоор АМГТГ-ын мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх 3 жилийн хугацаатай Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр АМГТГ болон MERIT төслийн хооронд тохиролцов.

Канад улс БОАЖЯ-ны уул уурхайн үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх зорилгоор дэвшилтэт технологи нэвтрүүлэх, ур чадвар дээшлүүлэх тал дээр туслалцаа үзүүлэв

MERIT төсөл нь БОАЖЯ-ны Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтэст Монгол улсын газрын нөхцөл байдлын талаар зурган баримтжуулалт хийж, нягтаршил сайтай зургийг агаараас авах GPS болон дрон зэрэг тоног төхөөрөмж гардуулж өгөв.



Тоног төхөөрөмж гардуулах ёслол, БОАЖЯ,
2017 оны 11 сар

Жендерийн ойлголт, жендерийн мэдрэмж, жендерийн эрх тэгш байдлын талаарх сургалт явуулав

MERIT төслийн жендерээр мэргэшсэн техникийн зөвлөхүүд нь АМГТГ, БОАЖЯ, УУХҮЯ, ГГХ, ШУТИС-т зориулж жендерийн ойлголт, мэдрэмж болон эрх тэгш байдлын талаарх сургалт явууллаа. Ажлын байран дээр жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудал нь гол сэдэв болж байсан.

Бүх түншлэгч талууд Монгол улсын жендерийн асуудалтай холбоотой үндсэн шаардлага, давуу болон сул талуудын талаарх ойлголт, мэдлэгээ сайжруулах хэрэгтэй байгаагаа илэрхийлсэн. Сургалтаар жендерийн талаарх ойлголт өгч, мэдлэг чадавхийг нь сайжруулсан.

Түүнчлэн MERIT төсөл нь төрийн байгууллагуудад жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотойгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн практик арга барилын талаар зөвлөгөө өгч байна. Тус ажлын хүрээнд УУХҮЯ, БОАЖЯ, ШУТИС, ГГХ болон Дорнод аймгийн ЗДТГ-ын жендерийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд НҮБ-ын жендерийн эрх тэгш байдлыг төлөвшүүлэх онлайн сургалт, мөн Бангкок хотноо болсон биечилсэн сургалтад хамрагдаж мэдлэг, чадвараа дээшлүүлж, ажлын байран дээр жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, зөвлөмжтэй танилцлаа. MERIT төсөл нь 2018 онд жендерийн аудит болон бусад жендерийн асуудалтай холбоотой ажлуудыг хийхээр төлөвлөсөн ба түншлэгч байгууллагуудад туслалцаа дэмжлэг үзүүлэн ажиллана.



НҮБ-ын Жендерийн эрх тэгш байдлыг
хангах сургалт, Бангкок, 2017 оны 10 сар

ГГХ-д мэдлэгийн менежментийн талаар зөвлөгөө өгөв

Мэдлэгийн менежментийн чиглэлээр мэргэшсэн төслийн техникийн зөвлөхүүд ГГХ-ийн мэдлэгийн менежментийн ур чадварыг хөгжүүлэх тал дээр хамтран ажиллав. Зөвлөхүүд мэдлэг төвтэй байгууллага болгохын тулд ГГХ-ийн хийх ажлын төлөвлөгөөг боловсруулав.

АМГТГ-ын дээд шатны удирдах ажилчдад зориулж Үр дүнд суурилсан менежментийн талаар ойлголт өгөх, чадавхи бэхжүүлэх сургалт явуулав

MERIT төслийн зүгээс АМГТГ-ын гол удирдлага, удирдах түвшний ажилчид болон хяналт үнэлгээнд зориулж Үр дүнд суурилсан менежментийн талаар ойлголт өгөх сургалт, семинар зохион байгуулав. Сургалтаар тодорхой, хэмжигдэхүйц үр дүнд тавьж ажиллахад оролцогчдын чадавхийг сайжруулахад тус дэм болох Үр дүнд суурилсан менежментийн агуулга, арга хэрэгсэл, практикийн талаар заав.

АМГТГ-ын Хүний нөөцийн дүн шинжилгээ хийв

Хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх зорилтын хүрээнд хүний нөөцийн чиглэлээр мэргэшсэн төслийн техникийн зөвлөхүүд эхний үе шатанд АМГТГ-ын ажлын байрны дүн шинжилгээг хийж гүйцэтгэв. Тус шинжилгээг хийснээр АМГТГ-ын хүрээнд ажилчдыг сургаж хөгжүүлэх

Товч үгийн тайлбар:

ШУТИС – Шинжлэх ухаан, технологийн их сургууль
БОАЖЯ – Байгаль орчин, аялал жуулчлалын яам
АМГТГ – Ашигт малтмал, газрын тосны газар

УУХҮЯ – Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ГГХ – Газар зүй, геоэкологийн хүрээлэн
НҮБ – Нэгдсэн үндэстний байгууллага

ЗДТГ – Засаг даргын тамгын газар

шаардлагатай байгаа талбарууд, шаардлагатай байгаа ур чадвар, мэдлэгийг тодорхойлоход тус дөхөм болох юм. Ажлын байрны дүн шинжилгээг хийхэд шаардлагатай баримт бичиг боловсруулах, арга хэрэгсэл, процессыг бий болгох тал дээр туслалцаа үзүүлэв. Энэ үе шатанд олж авсан мэдээлэл, хийж гүйцэтгэсэн дүн шинжилгээг дээрх зорилтын дараа дараагийн үе шатанд хэрэглэнэ.

АМГТГ-ын гол чадавхиудыг хөгжүүлэхэд туслав

Хүний нөөцийн чиглэлээр мэргэшсэн төслийн зөвлөхүүд дараагийн үе шатанд АМГТГ-ын гол чадавхиудыг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэв. Гол чадавхиуд гэдэг нь тухайн байгууллагын бүх үе шатны ажилчдыг ажлын байран дээр ажил үүргээ үр ашигтай гүйцэтгэхэд шаардлагатай байгаа гол чадавхиуд юм. Зөвлөхүүд АМГТГ-ын бүх түвшинд гол чадавхиуд, төлөвшүүлбэл зохих зан төлвийг тодорхойлж, төлөвшүүлэх талаар ажлын хэсэгт удирдамж өгч, үлгэрлэн дуурайлах, зөвлөн туслалцаа үйлчилгээ үзүүлэв. Тус ажлын үр дүнд байгууллагын бүх түвшинд байвал зохих зан төлвийн хамт зургаан гол чадавхийг тодорхойлов.

Канадын туршлагыг судлав

MERIT төслийн хүрээнд Дорнод аймгийн засаг захиргаа, жижиг дунд бизнес эрхлэгчдийн төлөөллийг хамруулсан 12 өдрийн туршлага судлах айлчлалыг Канад улсын Елловнайфе хотод зохион байгуулав. Төлөөлөгчид орон нутагтай хамтран ажиллах гэрээнүүд/газрын асуудал, орон нутгийн иргэдийг эдийн засгийн хувьд олборлох салбар, байгаль орчны менежментэд татан оролцуулах, олборлох салбарын сургалт санаачлага гэсэн чиглэлээр Канад улсын туршлагыг судлав.



Дорнод аймгийн төлөөлөл Канадын Елловнайфе хотноо, 2017 оны 11 сар

Дорнод аймгийн ЗДТГ-т ISO 9001 чанарын удирдлагын системийг нэвтрүүлэв

MERIT төслийн хүрээнд FMC зөвлөх үйлчилгээний компаниар дамжуулж Дорнод аймгийн ЗДТГ-т ISO 9001 чанарын удирдлагын системийг нэвтрүүлэв. ISO 9001 чанарын удирдлагын тогтолцоо нь аливаа байгууллагад үр ашигтай чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж ажилууллахад дэмжлэг үзүүлэх зорилготой хөгжиж ирсэн удирдлага, чанарын талаарх олон улсын бүлэг стандарт юм. ISO 9001-ийн үр дүнд ЗДТГ нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахын төлөө илүү үр дүнтэй ажиллах боломжтой болно.

Олборлох салбарт олон нийтийн хэлэлцүүлэг хийх удирдамж

Уурхайн нөлөөлөлд өртсөн иргэд зэрэг олборлох салбарын оролцогч талуудтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд улсын болон орон нутгийн засаг захиргааны хоорондох уялдаа холбоо, хамтын ажиллагаа, зөвшилцлийн арга практикийг сайжруулах шаардлагатай байгаа тул MERIT төслийн хүрээнд “Олборлох салбарт олон нийтийн хэлэлцүүлэг хийх удирдамж” нэртэй ном хэвлэн гаргав. Тус удирдамж нь уул уурхайн хайгуулын болон оператор компаниуд, орон нутгийн засаг захиргааны хооронд гэрээ байгуулах зэргээс авхуулаад тусгай зөвшөөрөл олгох, хууль тогтоомжинд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор оролцогч талуудын зөвшилцөл, хэлэлцээрийг боловсруулж хэрэгжүүлэхэд практик арга хэрэгсэл болж өгнө. Удирдамжийн зорилго нь арвин туршлагатай иргэний нийгмийн манлайлагчид, оролцогчид, улсын болон орон нутгийн засаг захиргааны албан хаагчдын ашиглаж болохуйц, аливаа шийдвэрийг

төлөвлөхөөс авахуулаад гаргасан эцсийн шийдвэрийн талаар мэдэгдэх гээд бүхий л зөвшилцлийн процессыг тоймлон танилцуулсан.

Канадын Гадаад хэргийн яам болон MERIT төслийнхөн Дорнод аймагт айлчлав.

Канадын Элчин сайдын яамны төлөөлөгчид Дорнод аймгийн удирдлагуудтай уулзалт хийхээр тус аймагт зочлов. Төлөөлөгчид Дорнод аймаг болон MERIT төслийн хоорондох түншлэлийн гол үйл ажиллагааны талаар танилцлаа.



Канадын Гадаад хэргийн яамны дэд захирал Люк Майерс 2017 оны 11 сард Дорнод аймагт зочлов

Дорнод аймагт дрон болон нээлттэй эх үүсвэр бүхий програм хангамжийн сургалт зохион байгуулав


MERIT төсөл нь SESMIM төсөлтэй хамтарч Дорнод аймаг дахь төслийн оролцогч талуудад зориулж дрон ашиглах талаар сургалт зохион байгуулав. Сургалт 4 өдөр явагдаж, 29 хүн хамрагдсан бөгөөд зураг авах ур чадварыг сайжруулах зорилгоор хүнд нөхцөл байдалтай газар нутагт хэрхэн дроноор нислэг хийх талаар заалаа. Сургалтанд БОАЖЯ, АМГТГ, ГГХ болон орон нутгийн засгийн газрын агентлагуудаас мэргэжилтэнүүд оролцов.

Дорнод аймгийн бэлтгэн нийлүүлэгчдийн судалгаа хийв

MERIT төслийн зөвлөхүүд Дорнод аймгийн ханган нийлүүлэлтийн сүлжээг сайжруулж, өргөтгөн тэлэх зорилгоор тус аймгийн олборлох салбарын нийлүүлэлтийн гинжин хэлхээний одоогийн байдал, боломжийн талаар судалгаа хийж гүйцэтгэв.

Канад улс АМГТГ-ын боловсрол, харилцаа холбооны хөтөлбөрийг дэмжиж онлайн сургалтын шинэ танхим нээж өгөв

Канадын Гадаад хэргийн яамнаас санхүүжилттэй MERIT болон SESMIM төслийн хүрээнд АМГТГ-ын чадавхийг бэхжүүлэх ажил хийсээр байна. Дээрх төслүүдийн хүрээнд засгийн газрын албан хаагчид, оролцогч талуудад зориулж онлайн болон биечилсэн сургалт явуулахад нь дэмжлэг үзүүлж, иж бүрэн тоног төхөөрөмжтэй сургалтын шинэ танхимыг хүлээлгэж өгөв.



АМГТГ дээрх Сургалтын танхимын нээлтийн ёслол, 2017 оны 12 сар

Бидэнтэй холбоо барих:

3 давхар, Нейшнл Таймс Нюс Тауер, Худалдааны гудамж, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар – 15160, Монгол улс
Утас: (976) 7610-5000, Цахим хаяг: support@merit.mn,



Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр MERIT төсөл хэрэгжиж байна.



CESOSACO



WUSC EUMC
Education Changes the World